

Дээд монголын уртын дуунд хийсэн хээрийн судалгааны үр дүн

Ан.Номунсан 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ 869249684@qq.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд БНХАУ-ын Хөхнуур мужид Дээд монголын уртын дуунд хийсэн хээрийн судалгааны үр дүнг танилцуулж байна.

Уг судалгааг хийхдээ, Дээд монгол уртын дууны үүсэл гарал, хавсрах хөгжимдүүр, тархац, зан үйл, онцлог, төрөл зүйлтэй холбогдох асуулгыг боловсруулан ярилцлага болон хээрийн судалгаа, цуглуулах, баримтжуулах, нэгтгэн дүгнэх зэрэг аргыг тус тус ашигласан. Судалгааны үр дүнд 170 гаруй уртын дууны эгшиг тэмдэглээ, 15 аудио болон дүрс бичлэгийг цуглуулан авч, Дээд монгол уртын дууны тархцын байдлыг төрөл зүйлд тулгуурлан тодруулж, уртын дуу зан үйлийн холбогдлыг дуулагдаж буй орчин, найр хуримын дэгтэй холбон авч үзэж, өнөөгийн оршин тогтож буй байдлыг тодорхойлох оролдлогыг хийлээ.

Түлхүүр үгс: Дээд монгол, урт дуу, хээрийн судалгаа, төрөл зүйл, тархац

The Results of field research conducted on the Upper Mongolian long song

Nomunsan An 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ 869249684@qq.com

Abstract: This paper documents field research findings on the Mongolian long-song tradition (urtyn duu) conducted in China's Qinghai Province. The study employed a mixed-methods approach combining thematic interviews on historical origins, instrumental accompaniment patterns, geographical distribution, and performative characteristics, with direct observation of ritual practices and systematic collection of 170 transcribed melodies alongside 15 audiovisual recordings. Through analyzing genre-specific transmission patterns and examining performance contexts within natural environments and wedding rituals, this investigation establishes an empirical framework for assessing the current preservation status of this UNESCO-designated intangible cultural heritage.

Keywords: Upper Mongolian, long song, field research, genre-specific, spread

Оршил

Дээд монголын уртын дууны түүхэн холбогдол (Үсрэнгүй 2019), зан үйл (Өлзий, Цэцэгмаа 2011), аман зохиол (Товчдоо 2010), төрөл зүйл (Үсрэнгүй, Эрдэнэцэцэг 2019), дууны аялгуу (Юүн Мэй 2022), шүлгийн хувилбар (Жа Ши Рү 2017), өвлөн уламжлал (Сэнгээ 2019), газар нутгийн онцлог шинж (Хөхшил 2019), тархац (Цолмон 2019)-ын талаас нь судалгаа шинжилгээ хийжээ.

Бид Дээд монгол уртын дууны судалгаанд төрөл зүйлийн ангиллын үүднээс хандах судалгаа хийх зорилгын нэгээхэн хэсэг нь энэхүү өгүүллээр илэрч байгаа билээ.

Дээд монгол уртын дууны төрөл зүйлийг дууны шүлэг, агуулга талаас нь нэлээд судалж олон янзаар ангилан үзсэн байдаг ч дууны төрөл зүйлийн ангилалд онолын үүднээс хандан хөгжмийн хэлбэр, дууны аялгууны онцлог, дуулагдах хэлбэр талаас нь тодруулах, мөн агуулга, зан үйлийн давхцал, ойлголтыг нягтлан үзэх шаардлага байна хэмээн үзсэн юм.

Иймд бид Дээд монгол уртын дуу дуулагдаж буй голомт болох Хөх нуур мужийн нутаг дэвсгэрт хээрийн судалгаа хийж, үр дүнгээр нь төрөл зүйлийн ангилал, тархац, дуулагдаж буй хэлбэр, холбогдох зан үйлийг нягтлах, олон соёлын нөлөөгөөр орхигдон гээгдэж, өөрчлөгдөн хувьсаж буй байдлыг тоон үзүүлэлтээр гаргахад энэхүү өгүүллийн ач холбогдол оршиж байна.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд чанарын судалгааны аргуудыг ашигласан бөгөөд дараах аргачлалуудыг хэрэгжүүлсэн болно. Нэгдүгээрт, асуулга боловсруулж, зорилтот бүлгийн дуу хөгжмийн өв, хэл найруулгын талаарх мэдлэг, хэрэглээ, ойлголтыг тодруулах зорилгоор Хөх нуур мужид 5 удаагийн хээрийн судалгаа хийсэн. Судалгааны явцад ганцаарчилсан ярилцлага, дунд хугацааны ажиглалт, дууны бичлэг цуглуулах зэрэг арга ашиглагдсан. Хоёрдугаарт, орон нутгийн ардын дууны тухай дуу бичлэг, ном зохиол, хэвлэгдсэн болон хэвлэгдээгүй бүтээлүүдийг цуглуулсан, хэл зүйн болон хөгжмийн бүтэц, сэдэв агуулгаар нь ангилж, төрөлжүүлсэн. Тус ангиллыг үндэслэн ардын дууны төрөл зүйл бүрийн онцлог, үг бүтэх тогтолцоо, хэрэглээний давтамж, үйл үгийн нөхцөл, нэр үгийн баймж зэргийг агуулгын дүн шинжилгээний арга ашиглан задлан шинжилсэн. Гуравдугаарт, мэдээлэл, ярилцлагын үр дүн, бичлэг, ном зүйн эх сурвалжуудыг синтезлэх замаар шинжилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж, дууны хэл найруулга, хөгжмийн хэлбэр, соёлын контекстийг хамтад нь харгалзан бүтцийн болон функцийн талаас шинжлэх арга зүйг баримталсан.

Судлагдсан үр дүн

Бид Хөх нуурт Дээд монгол уртын дууны хээрийн судалгаа хийхдээ дараах үндсэн 5 асуулгыг боловсруулан судалгааг хийсэн. Үүнд,

1. Дээд монголын уртын дууны үүсэл гарал
2. Дээд монголын уртын дууны хавсрах хөгжимдүүр
3. Дээд монголын уртын дууны тархац

4. Дээд монголын уртын дуутай холбогдох зан үйл
5. Дээд монголын уртын дууны онцлог, төрөл зүйл зэрэг болно.

Ярилцлага авах хүмүүсийн сонголтыг хийхдээ Дэлхий хот, соёлын ажилтан Сэцэнхүүгийн зөвлөгөөний дагуу 5 удаагийн хээрийн судалгаагаар 15 хүний нэрийг олж тодруулан судалгааг хийсэн. Ингэж судалгааг хийхдээ орон нутгийн байршил, тархац, өвлөн уламжлагчдын байдал, Дээд монголын уртын дууны төрөл зүйл, зан үйл, онцлог зэргийг харгалзан үзсэн болно.

2017 онд Шинин хот, Дэлхий хот, 2019 онд Баруун хошуу, 2020 онд Голмуд хот, 2023 оны 3 дугаар сард Хөхөд хошуу, Зүүн хошуу, 2023 оны 6 дугаар сард Хүрлэг хошуу, Дэлхий хотод тус тус судалгааг хийсэн.

Ярилцлагын үр дүнг нэгтгэн үзвэл,

Асуулга 1. Дээд монголын уртын дууны үүсэл гарлын талаар асуулгаас дүгнэн үзэхэд, “Дээд монгол гэх нэрийн үүсэл 360 гаруй жилийн түүхтэй. Миний бодлоор Дээд монголын дуу ая буй болсон цаг үе мөн иймэрхүү цаг хугацаагаар барагцаалбал буруугүй” (Чан 2020).

Дээд монголын уртын дууны үүсэл гарлын тухай нийт таван хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн. Эдгээр таван хүний хоёр нь Дээд монголын түүх бол гурван үе шат дамжиж Дээд монгол угсаатан бүрэлдсэн болно. Ингэхээр Дээд монголын уртын дуу бол нүүдэл, соёлыг дагалдан Хөх нуурт ирсэн байна гэж үзсэн. Нөгөө гурван хүн нь Дээд монголын уртын дуу бол монголчууд Хөх нуурт нүүдэллэж ирснээс хойш бүтээлч хүний далд ухамсрын хүрээнд бүтээгдэн үүссэн болно гэж үзжээ.


Асуулга 2. Дээд монголын уртын дууны хавсрах хөгжимдүүр

Дээд монголын уртын дууны хавсрах хөгжимдүүрийн тухай таван хүнтэй ярилцлага хийсэн байна. Тухайлбал, Бүрэнтөгс Дээд монголын уртын дуу нь дээр үед хавсрах хөгжимгүй (Бүрэнтөгс 2017), Баясгалан, Мөнх нар дээр үед ихлээр хавсран хөгжимддөг байсан (Баясгалан 2017) гэж онцолсон. Гэвч соёлын хувьсгалаас хойш тухайн бүс нутагт ихэл устаж, 1990-ээд оноос хойш морин хуур, лимбэ, ятга, ёочин г.м олон янзын хөгжимдүүрээр хавсран хөгжимддөг болсон байна. Үүнээс харахад, Дээд монголын уртын дууг хавсрах хөгжим байдаг юм. Гэвч соёлын хувьсгал болон хуурчид цөөхөн болсноор уртын дууг хавсрах хөгжим цөөхөн болж уртын дууг олон хүн цуг дуулдаг болжээ.

Асуулга 3. Дээд монголын уртын дууны тархац

Дээд монголын уртын дууны дуулагдах тархцын байдал ерөнхийдөө Зүүн хошуу, Баруун хошуу, Дэлхий хот гэх хэдэн газраар өргөн дуулагддаг юм (Сэцэнхүү 2017). Дээрх ярилцлагаас харахад, Дээд монголын уртын дууны тархац нь Дээд монголын бүс нутагт хамаарагдаж байгаа Ойрад монголчууд, Хошууд монголчууд болон Ганьсугийн Сүбэй монголчуудын дунд тархсан байсан юм.


Дээд монголын уртын дууны тархцын талаар 15 хүнтэй ярилцаж, асуулга авсан байна. Үүнд:



Зураг 1. Дээд монголын уртын дууны тархцын судалгаа
(15 хүнтэй хийсэн ярилцлагын дүнгээр)

Асуулга 4. Дээд монголын уртын дуутай холбогдох зан үйл

Дээд монголчуудад цагаан сарын баяр найр, ураг хуримын ёслол найр, хүүхдийн өрвөөний найр, намаржаа зуслангийн найр, шинэ гэр мялаах найр, засаг захиргааны буюу сүм хийдийн цуглаан, овооны тахилга, нуурын тахилга гэх зэрэг найр, ёслол олон байдаг (Чан 2020). Хурим найр, уул усны тахилга, шашин шүтлэгийн найр хурал, эзэн ноёдын ёслол, ураг хуримын хүндэтгэл баяр дээр цөм Дээд монголын уртын дууг дуулж ёс хүндэтгэлээ гүйцэтгэдэг ажээ. Дээрх ярилцлагуудаас харахад, Дээд монголын уртын дууг голдуу хурим найрт дуулдаг заншилтай болно. “Уртын дууны дуулах явц нь даамал, ерөөлч, дууч ка болон бүхэл шүүс, баянсөн, төрийн дуу, найрын дуу” гэх явцтай байна.



Зураг 2. Дээд монголын уртын дууны дуулагдах орчин
(15 хүнтэй хийсэн ярилцлагын дүнгээр)

Асуулга 5. Дээд монголын уртын дууны онцлог, төрөл зүйл

Дээд монголын онцлог төрөл зүйлийн асуултыг нийт 6 хүнтэй ярилцлага хийсэн байна. Онцлогийн хувьд:

- Зоригт: Дээд монголын уртын дууны онцлог гэвэл, дууны нахилга нь түргэн, ерийн монгол дуунаас хатуу бөгөөд огцом байдаг (Зоригт 2019).
- Говь: Нэг дуулсан дуугаа давтан дуулдаггүй, аялгууны хувьд огцом ордоггүй, тайван ордог, дууны үг шүлгийн хувьд олон “лаа” орсон байдаг. Энэ нь уртын дууны үгийн холбоос гэж үзэж болохоор байна (Говь 2023).
- Сүхбаатар: Дээд монгол уртын дууны нахилга нь Өвөр монгол болон Шинжаан монголын нугалаанаас эрс өөр байдаг. Дууны аялгуу нь огцом буурах буюу огцом дээшлэх хөдөлгөөн ихтэй байдаг (Сүхбаатар 2023).
- Мөнх: Дээд монголын уртын дуу нь хошуу хошуугаар бүр өөр байдаг. Манай хошуунд дунд өнгөөр дуулж байхад өөр хошуунд дээр өнгөөр дуулдаг. Энэ нь тухайн хүний хоолойноос шалтгаална. Үгийн хувьд дуу дуулж дуусах үест “шашин амар болтугай, төр түвшин амар болтугай” хэмээсэн төр шашнаа ерөөж сайшаасан үг арвин байдаг (Мөнх 2017).

Төрлийн хувьд: Уг асуулгатай холбоотой ярилцлагуудаас Дээд монголын уртын дууны онцлог нь хамт дуулдаг, аялгуу нь урт мөртөө огцом дээш явдаг, төрлийн талаас төрийн дуу, шашны сэдэвт дуу, найрын дуу, лали дуу, ерийн дуу гэсэн таван төрлөөр ерөнхийд ангилж үзсэн байна.



Зураг 3. Дээд монголын уртын дууны төрөл зүйлийн судалгаа
(15 хүнтэй хийсэн ярилцлагын дүнгээр)


Дээд монголын уртын дууг сурахад ихэнх нь аав, ээжээсээ сурч эхэлдэг. Харин тусгайлан багш залж дуу сурсан нь маш цөөхөн байдаг гэж Сүхбаатар багш өгүүлжээ. Дээд монголын уртын дууг дуулах хүмүүс 1960-1970 оны үед их байж, 1980-1990 он болоход дуулах хүмүүс нэлээд цөөхөн болсон байна. Гэвч 2008-2009 онд хошуу засгаас Дээд монголын уртын дууг хадгалан хамгаалахаар болж шинэ үеийн залуу дуучид Дээд монголын уртын дуугаа дахин дуулж, үргэлжлүүлэх болсон байна.

Долоон бүс нутгийн ерийн дууг ажиглахад, морио магтсан дуу 25, нутаг усаа магтсан дуу 21 байна. Үүнээс Дээд монголчууд нутаг ус, монгол морио магтан дуулах сэтгэхүй өндөр байна гэж үзэж болох талтай байна.


Судалгаанд баримтжуулагдсан дээрх төрлийн дуунуудыг нэгтгэн үзвэл,

Хүснэгт 1. Судалгаанд баримтжуулагдсан дуунуудыг нэгтгэсэн байдал

Тархсан байдал	Төрийн дуу	Шашин дуу	Найрын дуу	Лали дуу	Ерийн дуу	Нийт
Голмуд хот	4	5	3	1	9	22
Зүүн хошуу	12	5	5	8	11	41
Дэлхий хот	4	3	3	7	9	26
Хөхөд хошуу	3	3	3	3	3	15
Тайж нар хошуу	3	3	3	1	7	17
Хөрлөг хошуу	3	3	3	11	13	33
Баруун хошуу	3	3	6	1	9	22
Нийт	32	25	26	32	61	



Зураг 4. Дээд монголын уртын дууны төрөл зүйлийн ангилал



Зураг 5. Дээд монголын уртын дууг газар нутгаар ангилсан ангилал

Хэлэлцүүлэг

Дээрх долоон бүс нутгийн уртын дууг таван төрлөөр ажиглахад, Зүүн хошуу болон Хөрлөг хошууны уртын дуу өргөн тархсан байдлаар дуулагдаж байгаа бол нь бусад хошуу нутагт цөөн байгаа нь харагдаж байна. Үүнээс лали дуу болон ерийн дуу нь тооны хувь олон байна.

Дээд монголын уртын дуу нь шашин шүтлэгтээ үнэнч, жилийн буюу улирлын хөдөлмөрийн бүтээлээ бэлгэдсэн мал, унаганыхаа өнөр баялаг, нутаг усныхаа өргөн уудам, үзэсгэлэнт сайхныг магтсан буюу аав ээжийн ач гавьяа, ах дүүгийн хайр халамжийг өргөдөн санагалзаж хүндэтгэн магтсан шинжтэй байна. Мөн хойч үедээ гүн ухаалаг ёс зүйгээр сурган хүмүүжүүлсэн зэрэг утга агуулгыг хамарч байдаг.

Дүгнэлт

Бид Дээд монголын уртын дууны үүсэл гарал, тархац, уртын дуутай холбогдох зан үйл, уртын дууны онцлог, төрөл зүйл, уртын дууны хавсрах хөгжимдүүр зэрэг зүйлсийг тодруулах зорилготой асуулга боловсруулан 2019-2023 оны хооронд Хөх нуурт 5 удаагийн хээрийн судалгааг хийсэн билээ. Уг судалгааны явцад 15 өвлөн уламжлагчтай биечлэн уулзан ярилцлага хийж баримтжуулан, холбогдох ном, эрдэм шинжилгээний бүтээл, аудио болон дүрс бичлэгийг цуглуулсан. Судалгааны үр дүнг авч үзвэл,

- Төрөл зүйлийн хувьд сэдэв, агуулга, зан үйлтэй холбогдуулан төрийн дуу, шашны дуу, найрын дуу, лали дуу хэмээн ангилж, үүнээс ерийн дуу 34,6 буюу ихэнх, шашны дуу нь 14.20 буюу бага хувийг эзэлж байна. Холбогдох зан үйлийн хувьд ураг хурим болон найр хуримын зан үйлтэй холбогдох уртын дуу нь дийлэнх, харин шашин шүтлэг, уул усны тахилгатай холбогдох зан үйлийн дуу багахан хувийг эзэлж байна.
- Тархцын хувьд Дээд монгол уртын дуу нь Хөх нуурын долоон хошуу нутагт дэлгэрэн тархсан байна. Зүүн хошуу болон Хөрлөг хошууны нутагт уртын дуу харьцангуй өргөн тархсан, амьд уламжлал хэлбэрээр хадгалагдан дуулагдаж байгаа нь анзаарагдаж байна. Харин бусад хошуу нутгуудад уртын дууны тархалт харьцангуй хязгаарлагдмал, цөөн тоотой байгаа нь бүс нутгийн соёлын ялгаа, уламжлалт дууны хэрэглээ, аман уламжлалын өвлөлтийн түвшинг харуулж байна. Түүнчлэн судалгаанд дурдагдсанчлан төрийн дуу болон ерийн дуу нь тооны хувьд олон байгаа нь тухайн нутгийн дууны төрөл зүйлийн голлох чиг хандлагыг илэрхийлж байна.

Харин Дээд монгол уртын дууны үүслийн хувьд Дээд монголын уртын дуу бол нүүдэл, соёлын дагалдан Хөх нуурт ирсэн, монголчууд Хөх нуурт нүүдэллэж ирснээс хойш бүтээлч хүний далд ухамсрын хүрээнд бүтээгдэн үүссэн болно гэж үзэх үзэл баримтлалууд байгаа бол Дээд монголын уртын дууг хамсран хөгжимдөх хөгжимдүүрийн хувьд соёлын хувьсгалын нөлөөгөөр хуурчид цөөрч, бусад хөгжимдүүртэй хамсрах болон хамтаар дуулдаг уламжлал багагүй дэлгэрсэн байна.

Дээд монголын уртын дуу нь утга агуулгын хувьд гүн сэтгэлгээтэй, уламжлалт үнэт зүйлийг хадгалсан онцлогтой. Тухайлбал, шашин шүтлэгийн үнэнч хандлага, улирлын аж амьдралтай холбоотой мал сүргийн бэлгэдэл, нутаг усны гоо сайхныг бахдан магтах, эцэг эх, ах дүүгийн ач гавьяаг дурсан хүндэтгэх зэрэг сэтгэлгээ, ёс суртахууны өндөр агуулгатай байна. Мөн энэ төрлийн дуунд ирээдүй хойч үеийг ухаалаг, ёс суртахуунтай байлгахыг уриалсан ёс зүйн сургамж давамгайлж буй нь соёлын өвийн дамжуулалт, хүмүүжлийн үүргийг илтгэн харуулж байна.

Тус хэргийн судалгаа болон ном, эрдэм шинжилгээний бүтээлүүдээс Дээд монгол уртын дууг хөгжмийн талаас нь шинжлэн судалсан бүтээл ховор байгаа нь ажиглагдсан билээ.

Ашигласан материалын жагсаалт

- Жа Ши Рү. 2017. *Хэл, соёл зүйн хараан дахь дээд монголын ардын дуулал*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Өлзий, Цэцэгмаа. 2011. *Дээд монголын зан үйл*. Хөх хот: Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
- Сэнгээ, Ч. 2019. “Дээд монголын уртын дууг уламжлан хамгаалах асуудалд.” *Дээд монгол судлал, Дээд монголын соёл судалгааны нийгэмлэг*: 22.
- Товчдоо. 2010. *Дээд монголын ардын аман зохиолын цуглуулга*. Бээжин.
- Үсрэнгүй, Л. 2019. *Дээд монголын түүх хийгээд уламжлалт соёлын хувьсал*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Үсрэнгүй, Л., Эрдэнэцэцэг. 2019. *Дээд монгол судлал*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Хөхшил. 2019. *Дээд монголын төрийн дууны тухай анхны сүвэгчлэл*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Цолмон, У. 2019. “Дээд монголын зүүн хошууны ардын дууны тухай дөхөм ажиглалт.” *Дээд монгол судлал, Дээд монголын соёл судалгааны нийгэмлэг*: 318.
- Юүн Мэй. 2022. *Дээд монголын Жинхуагийн ардын дууны эмхэтгэл*. Хөх хот: Өвөр монголын Ардын хэвлэлийн хороо.

Ярилцлага:

- Баясгалантай хийсэн ярилцлага. Дэлхий хот: Дээд монголын Сурвалж бичгийн төв, 2017.01.07.
- Бүрэнтөгстэй хийсэн ярилцлага. Бээжин: Төвийн үндэстний их сургууль, 2017.07 05.
- Ван, Чантай хийсэн ярилцлага. Голмуд хот: Голмуд хотын музей, 2020.07 10.
- Говьтой хийсэн ярилцлага. Зүүн хошуу: Говь багшийн гэрт, 2023.03 05.
- Зоригттой хийсэн ярилцлага. Баруун хошуу: Зоригт багшийн гэр, 2019.03.24.
- Мөнхтэй хийсэн ярилцлага. Баруун хошуу: Мөнх багшийн гэрт, 2017.03.24.
- Сүхбаатартай хийсэн ярилцлага. Зүүн хошуу: Говь багшийн гэрт, 2023.03.05.
- Сэцэнхүүтэй хийсэн ярилцлага. Дэлхий хот: Дээд монголын Сурвалж бичгийн төв, 2017.01.27.